

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Намсрайн Гэндэн	Дугаар	L080
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Батноров
Төрсөн газар	Батноров сум	Төрсөн он	1928
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Харзны хийд ,Цантын хийд	Сүм хийдийн дугаар	ХЭБВ 109 ХЭБВ 110
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 18	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд

Хэнтий аймаг Батноров сумын Харзны хийд, Цантын хийд

-Танаас Харзны хийд ,Цантын хийдийн талаар асуух гэсэн юмаа?

Харзны хийдийг нэлээн дээхэн байгуулсан. Бага байсан даа.

-Та багадаа хурал хүрж байсан уу?

Манай аавын ах, аавын дүү гэж 3 лам байсан. Би 8 настай байсан. Тэд надад жоохон юм хэлж өгсөн. Гурвуул хэлмэгдэлд орсон.

-Хэн гэдэг хүмүүс байсан юм бэ?

Ах нь Данзангийн Лувсан 64-тэй хэлмэгдсэн, Наваангончиг гэж байсан. 49-тэй хэлмэгдэлд орсон. Шарав гэж байсан. 45-тай хэлмэгдээд. Шарав нь ирсэн.

-Тэд нар Дарь эхийн хийдэд хүрж байсан уу?

Тэд Бэрээвэнгийн улс. Хоёр нь. Нэг нь энд хүрж байсан Лувсан гэдэг нь. Наваангончиг нь хийдийн гэсгүй ч явсан. Өрлүүд аймгийн гэсгүй явсан. Шарав гэдэг нь Бэрээвэн хийдэд сууж байсан. Тэндээс баригдсан.

-Харзны хийдийн талаар сонссон юм байна уу?

Харзны хийдийн лам нарыг нь болохоос биш, дуганых нь талаар мэдэхгүй.

-Мяндагтнууд нь хэн хэн гэдэг хүн байсан бэ?

Шарав гэлэн гэж байсан. Тэр унзад нь байсан. Наваан Пэрэнлэй гэж байсан. Тэр лам нь байсан болов уу гэж санаж байна. Балжирын Шагдар гэж бага унзад нь байсан. Тэр саяхан нас барчихсан. Тэр уг нь хэлэх хүн байсан юм даа. Гүржэв гэж чомбо нь байсан. Олон ламтай байсан. 2 Гүржавтэй байсан. Зүтгээ Гүржав, шоовон Гүржав гэж. Дандаа хоч нь. Овгийг нь сайн мэдэхгүй байна. Харзны хийдийн талаар л яриад байгаа штээ.

-Гэсгүй нь хэн гэдэг хүн байсан бэ?

Нэрийг нь мартчаад байна.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Хэдэн дугантай байсан юм бол? Нэг л дугантай байсан юм болов уу?

Нэг биш ээ. 3 дуган гэвэл худал болохгүй байх. Их хуралтай байсан.

-Өдөр тутмын хуралтай байсан уу?

Байсан.Хийд бол манай сүмд олон байсан.Харзны хийд. Гол хийд гэж манай баруунтах хийд Дунд бүрдний хийд. Дээр үеийн хийд нь Түнтгэрийн хийд, Зосын хийд гэж байсан. Олон хийд байсан.

- Түнтгэрийн хийд гэж хаана байсан юм бэ?

Тэр зүүнтшээ Харзнаас баруун урагш Зүрхийн Бүрд гэж байдаг. Тэрнээс баруухан хойш. Харзны хийдээс бол хол. Цамтдаа ойр. Цамтын хийд гэж байсан. Лам нь Сандагийн Гэлэн гэж байсан. Чүлтэм гэдэг хүн байсан. Зодын хуралтай газар. Улааны чигийн.

-Хэр олон ламтай байсан бэ?

Харз бол олон байсан. Цантын хийдийн их лам нь Чүлтэм гэлэн гэж байсан. Тэр нь бие барчаад дараа нь Санжаа гэлэн гэдэг хүн болсон.Тэр бас барианы урд талд нас барсан. Цантын хийдийн гэсгүй нь Нуваанжамба гэж хүн байсан. Ер нь тэгээд улааны хийд болохоор эмэгтэй лам нар олон байсан.

-Холилдож хурдаг байсан уу? Тус тусдаа хурдаг байсан уу?

Холилдоод хурна. Нэг дорын хурал юм чинь.

-Сандагийн Гэлэн гэдэг хүн Цамтын хийдийг байгуулсан юм уу?

Байгуулсан юм.

-Хэдэн онд юм бол?

Ээ дээ тэрийг ч барахгүйгээр юм. Өргөжсөн нь миний бодлоор 1926,27 гээд байгаа юм. Тэрнээсээ урагш хэдэн жил байсныг нь мэдэхгүй юм. 20 гаран гэхэд худалч болохгүй биз дээ.

-Байгуулагдсан он нь уу?

Тийм ээ. Ердөө тэрийг мэдэх хүн ганц байгаад сая нас барчихлаа даа. Сая юу байхав дээ. Хоёр гурван жил болж байна. Цамтын хийдийн эрэгтэй лам нь цөөвөр байсан бол уу, Лувсандагва гэж байсан.Жамц гэж байсан. Лувсанжамц гэдэг байх аа.

-Цамтын хийдийн туурин дээр очиход туурины урдхан зоч нарын тэмдэг байна лээ. Тэр нь хадан дээр А үсэг сийлсэн байна лээ.

Тэмдэг байх ёстой. Ширээ гээд уул бий. Ерөөсөө А зурж байх ёстой. Жинхэнэ зоч хүн. Наян хэдэн онд нас барсан байх. Лувсанжамц гэдэг хүн байсан. Тэр бол гүйцэд жоржоо хийсэн хүн.

-Тэр А үсэг жорж хийсний тэмдэг биз дээ?

Тэмдэг. Аа тийм тийм төчнөөн үс булгаар явлаа гэсэн тэмдэг л ухаантай юм даа. Зүүн булаг, зүүн үхээртэй газраар явах номтой улс юм гэнэ лээ.

-Цамтын хийдэд хэдэн дуган байсан бэ?

Бас л гуравтай л байсан байх.

-Сахиус нь Жамсран сахиус байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Харзны сахиус нь Жамсран байсан баймаар юм. Цамтынх нь гол сахиус Минсаа Нинжид гэж байсан.

-Харзных бол Жамсран сахиустай байсан юм байна?

Харзных бол Жамсран. Миний сонссоноор Цамтынх бол нарийн хуралтай газар байсан гэж байгаа.Тэр А зурсан газар чинь Ширээ гэж жаахан толгой бий. Довцог бий. Туурины урд бий. Тэр жаахан явдалтай газар байсан. Урьдын цагаар буг дарж байсан гэсэн.

-Цамтын хийдэд цам гардаг байсан уу?

Цамтын хийдийн цам бол Мамын цам гардаг байсан. Мамын цамд ордог байсан Яримпилийн Шарав гэж хүн байсан.Мамын хувцас өмсөөд бээлий өмсөөд үнс манаргадаг байсан.Цамтын хийдэд Мамын довдог гэж байсан. Довдог гэдэг нь мамын цам гарч байсан.

-Өөр онцлох зүйл нь юу байв?

Эмэгтэй улс их олон байсан. Сөрөв гэж хүн байсан. Их уншлагатай. Аюуш ч гэж байсан. Пагмажав гэж байсан.

-Гурван дугандаа яаж хурдаг байсан юм бол?

Мамын цам гарахад их хурал болдог байсан.Зарим нь тохижилт энэ тэрээ хийдэг дуган одооны үгээр склад байсан байх. Мамын цам гэдэгт сор маягтай юм шатаадаг байсан байх гэж санаж байна. Хишигт гэж барьдаг тэр хийдийн эмэгтэй хүн байсан. Өлзийт гэж байсан.Тэд нар жамаараа нас барсан. Ганцхан Яринпил гэж тэндээс баригдсан.

-Цамтын хийдийн төвд нэр нь юу юм бол?

Тэрийг мэдэхгүй.

-Харзын хийдийн төвд нэр нь юу байсан бэ?

Сайн мэдэхгүй байна. Би тэр үед бага байсан болохоор ердөө мэдэхгүй байна. Миний сонссон бол энэ л байна.

-Энэ хоёр хийдийн жасын талаар?

Одоо тийм хөрөнгөтэй байсан юм уу, хөрөнгөгүй байсан юм уу мэдэхгүй. Ямар ч байсан жастай л байсан байх.

-Хийдүүдийн барилгын талаар?

Төвд маягийн дандаа модон дугантай байсан.

-Өөр Харзны хийдийн талаар нэмж хэлэх юм байна уу?

Алга даа.Одоо болчоод байна.

-Харзны хийд Хайлан хурдаг байсан уу?

Хайлан хурдаг байсан. Харзны хийд бол тэр Баруун хийдээс дутахгүй их юм хэрэглэж байсан газар. Дунд бүрдний хийдтэй зэрэгцдэг л газар байсан гэсэн.

-Энэ хоёр хийд маань хаагдсан тухай?

1928 онд үгүй хийсэн.1938 он гэсэн үг.Лам нарыг нь 1927 онд бариад барьсныхаа хойтон жил нь үгүй хийсэн.

-Хийдийн дуганын мод энэ тэрийг яасан юм бол доо?

Тэрийг гол нь баячууд хөрөнгө гаргаж хятадаар хийлгэсэн гэнэ лээ. 4 дугуйтай тэргээр мод авчирч барьсан гэнэ лээ. Монгол зөөгөөд хятад барьсан гэсэн. Баруун хийдийн дуган бол өмхрөөд байсан юм гэнэ лээ. Одоо шинэ

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

дуган барих уу яах вэ гээд. Өө яахав завсрыг нь бөглөчихөөд байна биз ингээд нэг өөр болно гэж байсан юм гэнэ лээ. Манай Баруун хийдийн цорж, хамба лам нь л ярьж байсан гэдэг. Гончиг гэж хүн байсан.

-Идэрмэгийн нэг гурван хийд байна.

Сэргэлэнгийн хийд гэж байсан юм гэнэ лээ. Сүжигтийн хийд гэж байсан юм гэнэ лээ. Сэргэлэнд нэг тарваган тахал гарсан гэнэ лээ. Тэгээд лам нар нь бултаараа тахлаар нас барсан гэдэг. Хоёр гуравхан лам үлдсэн юм гэдэг. Санжшарав гэдэг үлдсэн лам л гэж ярьдаг юм байна лээ. Сэргэлэнгийн хийд тэрнээс хойш сэргэсэн юмуу үгүй юмуу мэдэхгүй. Би Ононгийн Халуун рашаан гэдэгт Шарав гуайтай хамт явж байсан. Шарав гуай надаас нэлээн ахмад хүн байсан. Одоо байхгүй болсон. За тийм л байна даа. Өөр хэлэх юм алга даа.